ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН УДИРДАХ АЛБАН ТУШААЛТНЫ БОЛОВСРОЛЫН ХӨГЖИЛ, ТҮҮНИЙ ҮР НӨЛӨӨ.

Д.Энх-Амгалан.
Нийслэлийн цагдаагийн удирдах газрын захиргааны удирдлагын газрын төлөвлөлт, зохион байгуулалт, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн

Хураангуй: *Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх онцлогтойн хувьд уг байгууллагын бүх шатны нэгжийн удирдах албан тушаалтны боловсрол, мэргэжлийн хөгжил нь тухайн дарга гэхээс илүүтэй цагдаагийн хэтийн болон ойрын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх, цаг хугацааг наашлуулах, улмаар иргэдийн амар тайван амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд түлхэц болох дамжиггүй. Тиймээс ч байгууллагын үр дүн, үйл ажиллагааны чанарт ихээхэн нөлөөлөх нь гарцаагүй.*

Удирдах албан тушаалтнууд нь байгууллагын амжилт, бүтээмж, нийгмийн хариуцлага, чанарыг хангахад чухал үүрэгтэй. Тэдний мэдлэг, чадвар, мэргэжлийн хөгжил нь бүх ажилтнуудын амжилт, ажиллах урам зоригт нөлөөлдөг чухал ач холбогдолтой.

Тиймээс байгууллагын хөгжлийг хурдасгах хүч болох цагдаагийн удирдах алба хаагчдын боловсролын талаар холбогдох судалгааг харицуулсан судалж, улмаар өөрийн хувь нэмрээ оруулахад оршино.

Abstract: *As the police organization has the characteristics of fighting crime and violations and implementing law enforcement functions, the education and professional development of the leading officials of all levels of the organization is more important than that of the chief, to implement the long-term and short-term strategic plans of the police, to save time, and thus to lead a peaceful life for the citizens. It will definitely help to create the environment. Therefore, the quality of the organization's results and operations will definitely be greatly affected.*

Executives are critical to organizational success, productivity, social responsibility, and quality. Their knowledge, skills, and professional development are critical to the success and motivation of all employees.

Therefore, it is necessary to make a comparative study of the relevant research on the education of police officers, which is a force to accelerate the development of the organization, and then make its own contribution.

Түлхүүр үгс: *Боловсрол, хөгжил, чадвар, удирдах албан тушаалтан, бакалавр, магистр, доктор.*

Keywords: *Education, development, ability, executive officer, bachelor, master's8 Ph.D.*

Оршил.

Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх онцлогтойн хувьд уг байгууллагын бүх шатны нэгжийн удирдах албан тушаалтны боловсрол, мэргэжлийн хөгжил нь тухайн дарга гэхээс илүүтэй цагдаагийн хэтийн болон ойрын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх, цаг хугацааг наашлуулах, улмаар иргэдийн амар тайван амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд түлхэц болох дамжиггүй. Тиймээс ч байгууллагын үр дүн, үйл ажиллагааны чанарт ихээхэн нөлөөлөх нь гарцаагүй.

Боловсролын хөгжлийг мэргэжлийн сургалтаар буюу удирдлагуудын мэргэжил дээшлүүлэх сургалтуудыг тогтмол зохион байгуулж, шинэ хууль, дүрмүүд болон аюулгүй байдлын арга хэмжээнүүдийг танилцуулах, технологийн хөгжлийг дижитал болон мэдээллийн технологийн чиглэлээр сургалтууд явуулж, цагдаагийн байгууллагад шинэ технологийг нэвтрүүлэхэд бэлэн болгох, лидершип ба менежментийн сургалтыг удирдлагын ур чадварыг дээшлүүлэх сургалтуудыг зохион байгуулж, стратегийн шийдвэр гаргах чадварыг хөгжүүлэх, гадаад хамтын ажиллагааг олон улсын цагдаагийн байгууллагуудтай хамтран сургалт, туршлага солилцох зэргээр авч үзэн үе шаттайгаар хэрэгжүүлэх нь үр дүнтэй.

Дээр дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлсэнээр ажлын үр ашиг, байгууллагын соёл, иргэдийн итгэл, мэргэжлийн хөгжлийн дэмжлэг үзүүлж улмаар боловсролтой удирдагчид нь илүү сайн шийдвэр гаргах чадвартай болж, байгууллагын гүйцэтгэлийг сайжрах, мэргэжлийн хөгжил нь ажилтнуудын дотоод уур амьсгал, хамтын ажиллагааг сайжруулж, ёс зүйг дээшлүүлэх, сайн боловсролтой удирдлага нь иргэдийн цагдаагийн байгууллагад итгэх итгэлийг нэмэгдүүлж, нийгмийн аюулгүй байдлыг сайжрах, ажилтнуудын мэргэжлийн ур чадвар дээшилж, байгууллагын хүчин чармайлтыг нэмэгдүүлэх үр нөлөөтэй.

Үндсэн хэсэг.

Удирдах албан тушаалтныг байгууллагын стратеги, зорилго, үүрэг хариуцлагыг тодорхойлж, хэрэгжүүлэх, зохион байгуулах, удирдлагаар хангах үүрэгтэй хүн гэж тодорхойлсон. Тэд байгууллагын дотоод процессыг удирдаж, ажилтнуудын үйл ажиллагааг чиглүүлэх, багийн ажлыг зохион байгуулах, шийдвэр гаргах үйл явцад оролцдог.

Удирдах ажилтны гүйцэтгэх үүрэг:

Хүснэгт 1

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Тодорхойлолт
1	Стратегийн төлөвлөлт	Байгууллагын зорилго, үүрэг, стратегийг тодорхойлох.
2	Шийдвэр гаргалт	Асуудлуудыг шийдвэрлэх, асуудлын шийдлийг тодорхойлох.

3	Багийн удирдлага	Ажилтнуудыг чиглүүлэх, тэдний чадварыг хөгжүүлэх.
4	Харилцаа холбоо	Байгууллагын дотоод, гадаад харилцааг хангах.

Эзэмших чадварууд:

Хүснэгт 2

№	Ур чадвар	Тодорхойлолт
1	Лидершип	Багийнхныг урамшуулж, зорилго руу чиглүүлэх чадвар.
2	Шийдвэр гаргах	Шаардлагатай мэдээллийг хурдан, зөв дүгнэх чадвар.
3	Коммуникаци	Ойлголцол, мэдээллийг зөв, тод илэрхийлэх чадвар[1].

Удирдах албан тушаалтнууд нь байгууллагын амжилт, бүтээмж, нийгмийн хариуцлага, чанарыг хангахад чухал үүрэгтэй. Тэдний мэдлэг, чадвар, мэргэжлийн хөгжил нь бүх ажилтнуудын амжилт, ажиллах урам зоригт нөлөөлдөг чухал ач холбогдолтой.

Иймд удирдах албан тушаалтнууд дээр дурдсан стратегийн төлөвлөлт, шийдвэр гаргалт, багийн удирдлага, харилцаа холбоо, лидершип, шийдвэр гаргах, коммуникаци зэргийг мэдлэгийн түвшин, цаашлаад ахисан түвшиний боловсролын хэмжээст суралцаж, эзэмшсэн байх нь байгууллагын хэтийн зорилтод хүрэхэд дөхөм үзүүлэх нь гарцаагүй.

Нөгөө талаас төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэгч цагдаагийн байгууллагын удирдлагын онцлог нь дараах зарчмууд, бүтэц, үйл ажиллагаатай холбоотой байдаг байна.

- Зохион байгуулалт: Цагдаагийн байгууллага нь төвлөрсөн бүтэцтэй бөгөөд төв, орон нутгийн нэгжүүдтэй. Удирдлага нь хууль сахиулах, нийгмийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй.
- Засаглал: Цагдаагийн байгууллага нь төрийн гүйцэтгэх эрх мэдэлтэй шууд холбоотой бөгөөд хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.
- Үйл ажиллагааны стратеги: Удирдлага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн аюулгүй байдлыг хамгаалах стратеги, тактик боловсруулдаг.
- Сургалт, хөгжүүлэлт: Цагдаагийн алба хаагчдыг мэргэжлийн ур чадвар, ёс зүйгээр сургах, хөгжүүлэх нь удирдлагын чухал хэсэг.
- Коммуникаци: Нийгэмтэй харилцах, иргэдийн санаа бодлыг сонсох, мэдээлэл дамжуулах нь удирдлагын чухал үүрэг.
- Аюулгүй байдал, хариуцлага: Удирдлага нь алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, хариуцлага, сахилга батыг тогтоох үүрэгтэй.

Эдгээр нь цагдаагийн байгууллагын удирдах албан тушаалтны хэрэгжүүлэх үйл ажиллагаа тул удирдахуйн ухааны онцлог салбар гэж үзэх талтай.

[1] ChatGPT, AI, цахим мэдээлэл.

Дэлхийн улс орнуудын хөгжлийн түвшинг тогтоохдоо тухайн улсын боловсролын салбарт хөрөнгө оруулсан хэмжээг харгалзан үздэг[1]-тэй адилтхан цагдаагийн байгууллагын хөгжлийг хурдасдах хүч болох удирдах албан тушаалтныг үүнтэй дүйцүүлэн авч үзэх нь оновчтой.

Одоогийн байдлаар манай улсын боловсролын салбарын хувьд 100 төгрөгөөр авсан эд зүйл, бараа материалыг хэрхэн 1000 төгрөгөөр зарах талаар суралцуулж байгаа бол дэлхийн өсрөнгүй хурдацтай хөгжиж буй зарим улс /Бүгд Найрамдах Хятад Ард Улс зэрэг/-ууд хэрхэн 100 төгрөгөөс бага өртөгөөр үйлдвэрлүүлэх талаарх боловсрол, мэдлэгийг олгоход Боловсролын салбарын чиглэн ажилладаг байна.

Түүнчлэн манай улсын боловсролын салбарт агентлаг болон түүний харьяа нэгжийн удирдах албан тушаалтныг томилох шалгуур үзүүлэлтэд боловсролын түвшинг доктор байх шалгуурыг тавьдаг байна[2].

Иймийн тулд дурдсан бусад салбарын хэрэгжүүлж буй боловсролын зэргийн шалгуурыг цагдаагийн байгууллагын удирдах албан тушаалтанд томилогдож буй алба хаагчдад тавьж, бакалавр-магистр-доктор зэргээр ахиулах шаардлагатай гэж судлаачийн зүгээс харж байна.

Цагдаагийн бие бүрэлдэхүүнийг боловсролын байдлаар авч үзвэл:

Хүснэгт 3

№	Боловсролын түвшин	2021.08 сарын байдлаар /11.000 алба хаагч/		2024.09 сарын байдлаар /12.000 алба хаагч/		Тайлбар	Анхаарах
		Тоо	Хувь	Тоо	Хувь		
1	Доктор	12	0.1	12	0.1	=	Онцгой анхаарах
2	Магистр	1421	13.6	1356	11.3	Буурсан	
3	Дээд	5887	56.4	6792	56.6	=	Анхаарах
4	Тусгай дунд	710	6.8	804	6.7	Өссөн	Үгүй
5	Бүрэн дунд	2292	22	2904	24.2	Өссөн	
6	Бүрэн бус дунд	113	1.1[3]	132	1.1[4]	Өссөн	

Дээрх судалгаанаас дүгнэвэл **Бүрэн дунд** боловсролтой алба хаагчдын эзлэх хувь нэмэгдсэнээс бусад түвшинд мөн үетэй адил болон буурсан үзүүлэлтэй байна.

[1] МУИС-ийн Боловсрол судлалын тэнхимийн ахлах багш Ж.Үржинсүрэн /Ph.D/-гийн лекц.
[2] МУИС-ийн Боловсрол судлалын тэнхимийн ахлах багш Ж.Үржинсүрэн /Ph.D/-гийн лекц.
[3] Цагдаагийн байгууллагын Хүний нөөцийн бодлогын баримт бичиг. Уб., 2021.
[4] Цагдаагийн байгууллагын Хүний нөөцийн бодлогын баримт бичиг. Уб., 2024.

Иймд цагдаагийн байгууллагын удирдлагын зүгээс хуулиар олгогдсон гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд ахиц гаргахын тулд алба хаагч /боловсон хүч/-дын боловсролд анхаарал хандуулж, ажлын ачаалал, бусад нөхцөл байдлыг харгалзан үе шаттайгаар суралцуулах шаардлагатай гэж үзэж байна.

Нөгөө талаас одоогийн байдлаар Нийслэлийн цагдаагийн удирдах газар, түүний харьяа газар, хэлтэс, тасгийн дарга нарын боловсролын байдлаар авч үзвэл:

Хүснэгт 4

№	Албан тушаал	Нийт алба хаагчийн тоо	Боловсролын түвшин		
			Бакалавр	Магистр	Доктор
1	Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Дэд дарга	2	-	2	-
2	Дүүргийн цагдаагийн газрын дарга	6	-	6	-
3	Хэлтсийн дарга	22	2	20	-
4	Дүүргийн Дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга	14	3	11	-
5	Тасгийн дарга	43	16	27[1]	-

/Хүснэгт 4-ийн судалгаанаас авч үзвэл цагдаагийн алба хаагч биднийг Нийслэлийн хэмжээнд бакалавр боловсролтой Хэлтсийн дарга 2, Дүүргийн Дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга 3, Тасгийн дарга 16 нийт 21 мөрдөс нэгт маань удирдаж байна. Үүнд тайлбар болон дүгнэлт хийх шаардлагагүй бизээ/

Дээрх бүх албан тушаалтнуудын албан тушаалын тодорхойлолтод боловсролыг-**Дээд боловсролтой, Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх**-аар заасан байна. /Бүгд албан тушаалын тодорхойлолтын боловсролын шаардлагыг хангасан/

Дээд боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-т “Багц цагийн хэмжээ нь дэд бакалаврын зэрэгт **90** багц цагаас доошгүй, бакалаврын зэрэгт **120** багц цагаас доошгүй, магистрын зэрэгт **30** багц цагаас доошгүй, докторын зэрэгт **60** багц цагаас доошгүй байна.[2]” гэж заасны дагуу “Ардын уламжлалт үгс болох номын дуу сонгох” зүй ёсны гэж үзэж байна.

[1] Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Хүний нөөц, сургалтын хэлтсийн тоон мэдээлэл. Уб., 2024.
[2] Дээд боловсролын тухай хууль. Уб., 2023.

Оюун санааны сэтгэлгээ, ёс суртахууны талаас сонирхон авч үзвэл Адаг баян адуу мал, Дунд баян үр хүүхэд, Дээд баян эрдэм ном[1] гэгчлэн боловсролын түвшинд онцгойлон анхаарах ёстой.

Цагдаагийн албаны тухай хуулийн 74 дүгээр зүйл[2]-д цол ахих хугацаанд дүн шинжилгээ хийн авч үзвэл:

Хүснэгт 5

Албан тушаалын байдлаар						
Гүйцэтгэх		Ахлах		Тасгийн дарга	Тасгийн даргаас дээш	
Дэслэгч	Ахлах дэслэгч	Ахмад	Хошууч	Дэд хурандаа	Хурандаа	Тайлбар
3 жил						**Бакалавр**
6 жил						**Бакалавр**
10 жил						**Магистр**
15 жил						**Магистр**
21 жил						**Доктор**
Дүгнэлт: Дээрх цаг хугацааны нөхцөл байдлыг ажилласан жил, туршлага, албан тушаал дэвших, шийдвэр гаргалт зэрэгтэй уялдуулах тайлбар хэсэгт дурдсан боловсролыг эзэмшсэн байх.						

Одоогийн байдлаар цагдаагийн байгууллагын удирдах албан тушаалтын сонгон шалгаруулалтыг хууль эрх зүйн мэдлэг, албан хэрэг хөтлөлт, боловсруулалт, хамт олны дунд нэр хүндтэй, хүлээн зөвшөөрөгдсөн, хувь хүний ёс зүй, харилцааны соёл, манлайлал зэргийг тухайн байгууллагын алба хаагчдаас авсан санал асуулгаар тодорхойлж, судалгааны дүнг нэг шалгуур үзүүлэлт болгон, бие бялдрын болон полиграф ашиглан алба хаагчдын зан төлөвийг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлох байдлаар шалгалт[3] авч өндөр онооны системээр томилж байна.

Одоогийн энэхүү байдалд нэмэлт оруулж, алба хаагчийн хашиж буй албан тушаал, ажилласан хугацаа, цол, бусад нөхцөл байдлыг харгалзан, урьдчилан удирдах албан тушаалд томилогдох алба хаагчдын боловсролын зэргийг ахиулахаар тодорхой сургууль /Дотоод хэргийн их сургууль, Удирдлагын академи гэх мэт/-д гэрээгээр суралцуулах замаар ирээдүйн боловсон хүчнийг бэлтгэх нь үр дүнтэй гэж үзэж байна.

[1] Соён гийгүүлэгч, их эрдэмтэн, зохиолч, дуун хөрвүүлэгч, угсаатны зүй судлаач Еншөөбү овогт Бямбын Ринчен гуайн нэвтрүүлгийн хэсгээс.
[2] Цагдаагийн албаны тухай хууль. Уб., 2017.
[3] https://police.gov.mn/a/7270. Цахим сайт.

Дүгнэлт.

Цагдаагийн байгууллагын удирдах албан тушаалтны боловсролын хөгжил нь байгууллагын амжилтын үндэс юм. Тиймээс энэ чиглэлд анхаарал хандуулж, системтэй, тогтвортой хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай. Боловсролтой, чадварлаг удирдлага нь цагдаагийн байгууллагын хөгжлийг хурдасдах хүч болсноор гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, иргэдийн амар-тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ гэж дүгнэж байна.

Санал.

Сэдвийн хүрээнд цугларсан баримт, бичвэрт болон судалгаанд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна.

а/Тасгийн дарга болон түүнээс дээш албан тушаалд томилогдох алба хаагчдын албан тушаалтын тодорхойлолтын боловсролын шалгуурт цагдаагийн албаны тухай хуулийн 74 дүгээр зүйлд дүн шинжилгээ /Хүснэгт 5/ хийсэн дүгнэлтэд дурдсанаар өөрчлөлт оруулах.

б/Удирдах албан тушаалд томилогдох алба хаагчдын сонгон шалгаруулалтад Генетик тест[1] зэрэг бусад шинжлэх ухаанаар нотлогдсон арга зүйг ашиглах.

в/Алба хаагчийн хашиж буй албан тушаал, ажилласан хугацаа, цол, бусад нөхцөл байдлыг харгалзан, урьдчилан удирдах албан тушаалд томилогдох алба хаагчдын боловсролын зэргийг ахиулахаар тодорхой сургууль /Дотоод хэргийн их сургууль, Удирдлагын академи гэх мэт/-д гэрээгээр суралцуулах замаар ирээдүйн боловсон хүчнийг бэлтгэх.

Эх сурвалж.

- Цагдаагийн албаны тухай хууль. УБ., 2017.
- Дээд боловсролын тухай хууль. УБ., 2023.
- Цагдаагийн байгууллагын Хүний нөөцийн бодлогын баримт бичиг. Уб., 2021.
- Цагдаагийн байгууллагын Хүний нөөцийн бодлогын баримт бичиг. Уб., 2024.
- Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Хүний нөөц, сургалтын хэлтсийн тоон мэдээлэл. Уб., 2024.
- Соён гийгүүлэгч, их эрдэмтэн, зохиолч, дуун хөрвүүлэгч, угсаатны зүй судлаач Еншөөбү овогт Бямбын Ринчен гуайн нэвтрүүлгийн хэсгээс.
- https://police.gov.mn/a/7270. Цахим сайт.

[1] Дерматоглифик нь 1926 онд шинжлэх ухааны салбар болж үүссэн. 2011 онд 140 гаруй эрдэмтдийн судалгаанд үндэслэж программыг гаргасан /Хурааны хээ нь хүний тархины мэдээллийг агуулдаг/.